



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/394

Номгон

"Эх хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын  
үзүүлэх нөлөөллийг бууруулах нь" төслийг  
2023-2026 онд хэрэгжүүлэх ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ажиллах санамж бичиг, Улс орныг дэмжих хөтөлбөрийн хүрээнд орон нутагт "Эх хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөг бууруулах нь" төслийг 2023-2026 онд хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Баянхонгор аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн

Боловсрол, шинжлэх ухааны газрын Хүүхдийн хөгжил хамгаалал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Гамшиг яаралтай тусламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвийн нарийн бичгийн дарга

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн

"Цэвэр агаарын төлөө орон нутгийн санаачилга" ТББ-ын захирал

"Баянхонгор Эрчим хүч" цахилгаан түгээх ХХК-ний Ерөнхий инженер


Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн

2.НҮБ-ын Хүүхдийн сантай байгуулсан гэрээний биелэлтийг орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдуулан хангаж, олон нийтэд сурталчилан таниулах, төсөл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, төслийн үйл ажиллагааны тайланг аймгийн Засаг даргын дэргэдэх Удирдлагын багт хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН